ТӨСӨЛ
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2018 оны .... дугаар сарын ....-ны өдрийн ...
дугаар тушаалын хавсралт

# ТӨМС, ХҮНСНИЙ НОГООГ ХАДГАЛАХ ҮЕИЙН ХЭВИЙН ХОРОГДЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн хүнсний дэлгүүр, худалдааны төв, хүнсний захууд, зоорь агуулахын аж ахуй эрхлэгчид, тариаланчид төмс, хүнсний ногооны хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг энэхүү аргачлалын дагуу тооцно.

Нэг. Төмс, хүнсний ногоог богино хугацаанд хадгалах үеийн хэвийн хорогдлыг 1-р хавсралтаар баталсан нормоор тооцно.

1.1 Төмс, хүнсний ногоог хүнсний дэлгүүр, худалдааны төв, хүнсний захуудад худалдан борлуулах болон 20 хоног хүртэл хугацаанд зоорь, агуулахад хадгалах үеийг богино хугацааны хадгалалтын үе гэнэ.
1.2 Төмс, хүнсний ногооны богино хугацааны хадгалалтын үеийн хэвийн алдагдлыг жилийн дөрвөн улирал (хавар, зун, намар, өвөл)-аар тооцно.
1.3 Төмс, хүнсний ногооны богино хугацааны хадгалалтын үеийн хэвийн алдагдлыг хөргүүртэй агуулахад тооцоход худалдааны төвийн хөргүүртэй лангууг адилтгаж үзнэ. Төмс, хүнсний ногоог ил талбайд борлуулах, хүнсний захын задгай лангуунд борлуулахыг хөргүүргүй агуулах, зооринд түр хугацаагаар хадгалахтай адилтгаж үзнэ.

Хоёр. Төмс, хүнсний ногоог богино хугацаанд хадгалах үеийн хэвийн хорогдлыг 2-р хавсралтаар баталсан нормоор тооцно.

1.1 Төмс, хүнсний ногоог 20 хоногоос дээш хугацаатай хадгалахыг урт хугацааны хадгалалтын үе гэнэ.
1.2 Төмс, хүнсний ногооны урт хугацааны хадгалалтын үеийн хэвийн алдагдлыг жилийн 12 сар тус бүрээр тооцно.
1.3 Төмс, хүнсний ногоог урт хугацаанд хадгалахад зоорийн бичил уур амьсгал болох халаалт, хөргөлт, агааржуулалт, салхижуулалтыг тохируулах автомат мэдрэгчтэй механикжсан зоорийг албадан хөргөлттэй зооринд оруулж тооцно. Агаарын даралтын зөрүүгээр агааржуулалтыг тохируулах оруулах гаргах хоолойтой, энгийн халаалттай энгийн зоорь, нүхэн зоорийг албадан хөргөлтгүй зоорь, агуулахад оруулж тооцно.

Гурав. Төмс, хүнсний ногооны хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох жишээ

Жишээ 1: Эртийн болцтой байцааг 7-р сарын 15-нд түүвэрлэн 5000 кг ургац хураасан байна. Ургацаа 10 хоногийн дотор энгийн зооріндоо хадгалж, хүнсний задгай захад худалдан борлуулсан байна. Борлуулалтын үеийн хэвийн хорогдлыг тооцсон хэмжээг тодорхойл.

Төмс, хүнсний ногоог богино хугацаанд хадгалах үеийн хэвийн хорогдлыг 1-р хавсралтаар баталсан нормоор тооцно.

5000 кг – 5000 кг х 2,0/100 = 5000 кг-100 кг = 4900 кг.

Жишээ 2: Энгийн зооринд 9-р сарын 10-нд 10 тонн төмс зоорилон 1-р сарын 25-нд гэрээний дагуу хүнсний их дэлгүүрийн сүлжээнд нийлүүлсэн. Төмсний хадгалалтын үеийн

хэвийн хорогдол , борлуулалтын үеийн хэвийн хорогдлыг тооцсон бодит хэмжээг тодорхойлно уу.

А.Хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг 2-р хавсралтаас 9, 10, 11, 12, 1-р саруудын хорогдлын хувийн нийлбэрээр тооцно.

10тн – 10тн * (1.5+1,1+0,8+0.6+0.6)/100 = 10тн – 10тн * 4,6/100 = 10 тн – 0,46 тн = 9,54 тн буюу 9540 кг болж байна.

Б.Борлуулалтын үеийн хэвийн хорогдлыг 2-р хавсралтын өвлийн улирлын нормоор тооцно.

9540 кг – 9540 кг * 0,2/100 = 9540 кг – 9540 кг*0,2/100 = 9540 кг – 190,8 кг = 9349 кг

Хавсралт 1. Төмс, хүнсний ногоог худалдан борлуулах болон богино хугацаанд хадгалах үеийн хэвийн хорогдлыг тооцох норм

| Бүтээгдэхүүний нэр | Агуулах, зоорийн төрөл | Хэвийн хорогдлын норм, улирлаар % | | | |
|---|---|---|---|---|---|
| | | намар | өвөл | хавар | зун |
| Оройн төмс | Хөргүүртэй | 0,6 | 0,2 | 0,2 | 0,4 |
| | Хөргүүргүй, энгийн | 0,8 | 0,3 | 0,3 | 0,6 |
| Эртийн төмс | Хөргүүртэй | - | - | - | 0,5 |
| | Хөргүүргүй, энгийн | - | - | - | 0,6 |
| Дунд оройн болцтой байцаа (цагаан, толгойт байцаа, улаан толгойт байцаа) | Хөргүүртэй | 0,9 | 0,5 | 0,8 | - |
| | Хөргүүргүй, энгийн | 1,1 | 0,8 | 1,0 | - |
| Эртийн байцаа | Хөргүүртэй | - | - | - | 1,6 |
| | Хөргүүргүй, энгийн | - | - | - | 2,0 |
| Броколли байцаа | Хөргүүртэй | 1,2 | - | - | 2,1 |
| | Хөргүүргүй, энгийн | 1,5 | - | - | 2,5 |
| Үндэс үртэн (шар манжин, хүрэн манжин, шар лууван бусад) | Хөргүүртэй | 0,7 | 0,5 | 0,6 | 1,0 |
| | Хөргүүргүй, энгийн | 1,4 | 0,7 | 0,8 | 1,9 |
| Улаан лууван | Хөргүүртэй | 0,6 | - | - | 0,8 |
| | Хөргүүргүй, энгийн | 0,9 | - | - | 1,0 |
| Бөөрөнхий сонгино | Хөргүүртэй | 0,6 | 0,3 | 0,5 | 0,5 |
| | Хөргүүргүй, энгийн | 0,8 | 0,5 | 0,7 | 0,8 |
| Сармис | Хөргүүртэй | 0,5 | 0,4 | 0,5 | 0,7 |
| | Хөргүүргүй, энгийн | 0,6 | 0,6 | 0,7 | 1,0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Урт сонгино | Хөргүүртэй | 0,7 | - | 0,6 | 1,0 |
| | Хөргүүргүй, энгийн | 1,0 | - | 1,0 | 1,3 |
| Навчит ногоо | Хөргүүртэй | 1,4 | 0,7 | 0,8 | 1,3 |
| | Хөргүүргүй, энгийн | 2,0 | 1,0 | 1,1 | 1,9 |
| Хэмх | Хөргүүртэй | 0,7 | 0,4 | 0,4 | 0,9 |
| | Хөргүүргүй, энгийн | 1,0 | 0,6 | 0,6 | 1,4 |
| Лооль | Хөргүүртэй | 0,7 | 0,2 | 0,2 | 0,6 |
| | Хөргүүргүй, энгийн | 1,0 | 0,4 | 0,4 | 1,2 |
| Цэс, амтат болон гашуун чинжүү | Хөргүүртэй | 0,8 | 0,5 | 0,5 | 0,7 |
| | Хөргүүргүй, энгийн | 1,4 | 0,6 | 0,6 | 1,4 |
| Гуатан ургамал (тарвас, хулуу, амтат гуа) | Хөргүүртэй | 0,3 | 0,3 | 0,3 | 0,3 |
| | Хөргүүргүй, энгийн | 0,4 | 0,4 | 0,5 | 0,6 |

Тайлбар: Төмс, хүнсний ногоог богино хугацаанд хадгалах үе гэж худалдан борлуулах үеийн болон урт хугацаагаар зоорилоын өмнө хатаах, ялгаж ангилах технологийн зориулалттай саравч, агуулахад 20 хүртэл хоног хадгалахыг хэлнэ.

Хавсралт 2. Төмс, хүнсний ногоог урт хугацаанд хадгалах үеийн хэвийн хорогдлыг тооцох норм

| Бүтээгдэхүүний нэр | Агуулах, зоорийн төрөл | Хэвийн хорогдлын норм, сараар % | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 9-р сар | 10-р сар | 11-р сар | 12-р сар | 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар |
| Төмс | Албадан хөргөлттэй | 1,2 | 0,7 | 0,7 | 0,6 | 0,6 | 0,6 | 0,6 | 0,8 | 1,0 | 1,1 | 1,1 | 1,0 |
| | Албадан хөргөлтгүй | 1,5 | 1,1 | 0,8 | 0,6 | 0,6 | 0,6 | 0,6 | 1,1 | 1,4 | 2,1 | 2,3 | - |
| Хүрэн манжин, шар манжин | Албадан хөргөлттэй | 1,5 | 0,8 | 0,8 | 0,7 | 0,6 | 0,6 | 0,6 | 0,8 | 0,9 | 0,9 | - | - |
| | Албадан хөргөлтгүй | 1,7 | 0,9 | 0,8 | 0,7 | 0,6 | 0,6 | 0,6 | 1,0 | 1,3 | 2,1 | - | - |
| Шар лууван | Албадан хөргөлттэй | 2,2 | 1,4 | 1,2 | 0,8 | 0,7 | 0,9 | 0,9 | 1,2 | 1,2 | 1,2 | - | - |
| | Албадан хөргөлтгүй | 2,3 | 2,0 | 1,3 | 0,8 | 0,7 | 0,8 | 1,0 | 1,2 | 2,4 | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Оройн байцаа | Албадан хөргөлттэй | - | 2,6 | 1,6 | 1,2 | 1,0 | 1,0 | 1,3 | 1,3 | 1,8 | 1,8 | - | - |
| | Албадан хөргөлтгүй | - | 3,0 | 2,3 | 1,3 | 1,3 | 1,2 | 1,3 | 1,5 | - | - | - | - |
| Тавaарын бөөрөнхий сонгино | Албадан хөргөлттэй | 0,8 | 0,7 | 0,6 | 0,5 | 0,5 | 0,5 | 0,6 | 0,8 | 1,1 | 1,2 | 1,5 | 1,5 |
| | Албадан хөргөлтгүй | 1,7 | 1,2 | 1,1 | 0,6 | 0,6 | 0,6 | 0,6 | 1,0 | 1,7 | - | - | 2,5 |
| Сармис | Албадан хөргөлттэй | 1,6 | 1,0 | 0,9 | 0,9 | 0,9 | 0,9 | 0,9 | 0,9 | 1,5 | 1,5 | 1,5 | 1,7 |
| | Албадан хөргөлтгүй | 3,0 | 2,0 | 1,2 | 1,1 | 1,1 | 1,2 | 1,3 | 1,5 | - | - | - | - |
| Хулуу | Албадан хөргөлтгүй | 1,5 | 1,2 | 0,7 | 0,5 | 0,3 | - | - | - | - | - | - | - |

Тайлбар: Төмс, хүнсний ногоог урт хугацаанд хадгалах үе гэж технологийн шаардлага хангасан зоориндд ялгаж ангилаад задгай болон 20-иос дээш хоногоор хадгалахыг хэлнэ.